Авлага дансны эхний үлдэгдэл 29,331.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 33,813.7 сая төгрөг болж, 4,482.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	122.7	214.9	92.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	49.5	360.3	310.8
Татаас, санхүүжилтийн авлага		794.4	794.4
Зээлийн хүүгийн авлага	61.1	74.4	13.3
Дансны авлага	17,046.8	19,011.7	1,964.9
Бусад авлага	11,869.3	13,208.6	1,339.3
Зээлийн авлага	182.1	149.4	-32.7
Дүн	29,331.5	33,813.7	4,482.2

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үүссэн авлагаас 12,703.4 сая төгрөг буюу 37.6 хувийг төвийн байгууллага, 21,040.7 сая төгрөг буюу 62.2 хувийг ОНӨААН болон ОНӨОААН, 19.3 сая төгрөг буюу 0.06 хувийг төсөл сан, 50.3 сая төгрөг буюу 0.14 хувийг төрийн сангийн авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдлийн насжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

№	Данс	Үлдэгдэл дүн	Авлагын насжилт		
			1 жил хүртэл	1-5 жил	5 жилээс дээш
A	АВЛАГЫН ДҮН	33,813.70	19,150.20	5,802.50	8,860.90
1	Ажиллагсадтай холбоотой авлага	214.90	185.20	29.40	0.30
1.1	Төсөв байгууллага	110.50	85.10	25.40	-
1.2	ОНӨААН болон ОНӨОААН	104.40	100.10	4.00	0.30
2	Дансны авлага	19,171.60	15,987.70	2,840.40	343.50
2.1	Төсөв байгууллага	0.40		0.40	
2.2	ОНӨААН болон ОНӨОААН	19,171.20	15,987.70	2,840.00	343.50
3	Татвар НДШ-ын авлага	200.30	198.70	1.10	0.50
3.1	ОНӨААН болон ОНӨОААН	200.30	198.70	1.10	0.50
4	Байгууллагаас авах авлага	11,163.90	2,230.10	2,394.60	6,539.20
4.1	Төсөв байгууллага	9,213.60	1,431.10	1,664.10	6,118.40
4.2	ОНӨААН болон ОНӨОААН	1,516.20	779.60	730.50	6.10
4.3	Төсөл сан	383.80	19.4	-	364.40
4.4	Төрийн сан	50.30	-	-	50.30
5	Хувь хүмүүсээс авах авлага	3,063.00	548.50	537.00	1,977.40
5.1	Төсөв байгууллага	407.60	127.30	44.50	235.80
5.2	ОНӨААН болон ОНӨОААН	48.60	4.30	38.00	6.20
5.3	Төсөл сан	2,606.80	416.9	454.50	1,735.40

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Таван жилээс дээш насжилттай 8,861.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд 1995-2002 онд газар тариалан эрхлэх, өвс тэжээлийн нөөц бэлтгэх, 2013 оноос хойш олгосон сум хөгжүүлэх сангийн зээл, 2000-2011 онд ЖДҮДС, 2013-2014 онд “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд үүссэн орон сууцны сангийн зээлийн авлагууд байгаа нь төсвийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, эзэн холбогдогч тодорхойгүй болох эрсдэл дагуулж байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэг ажиллагсадтай холбоотой 1.1 сая төгрөг, хувь хүмүүсээс авах 1.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Сэврэй сумын ЗДТГ өвс тэжээлтэй холбоотой 1.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн,
- Цогтцэций сумын ЗДТГ нэмэлт санхүүжилтийн данснаас санхүү хяналт, аудитын албаны актын төлбөр 1.7 сая төгрөг шилжүүлэн авлагын дансанд тусгаагүй,
- Ханбогд сумын “Хот тохижилт” ОНӨААТҮГ 13.8 сая төгрөгийн авлагыг тооцоо хийж, үлдэгдлийг актаар баримтжуулаагүй,
- Таван толгой ХК 1,096.1 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2,420.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,594.2 сая төгрөг болж, 174.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,411.4	2,476.1	64.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	111.4	111.4
Цалингийн урьдчилгаа	8.7	6.7	2.0
Дүн	2,420.1	2,594.2	174.1

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2,594.2 сая төгрөг буюу 95.4 хувийг урьдчилж гарсан зардал эзэлж байна. Үүнд:

- Таван толгой ХК 2,247.1 сая төгрөг,
- Аймгийн ЗДТГ 109.2 сая төгрөг,
- Аймгийн Музей 96.5 сая төгрөг,
- Хөгжил хөрөнгө оруулалтын газар 56.6 сая төгрөг,
- Ханбогд хот тохижилт 23.3 сая төгрөг байна.

3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 7,974.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 434.2 сая төгрөг болж, 7,540.0 сая төгрөг болж буурсан байна.

Хүснэгт №5 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат ХО-г зам гүүр	7,974.2	434.2	7,540.0
Дүн	7,974.2	434.2	7,540.0

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 19,348.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 51,193.5 сая төгрөг болж, 31,884.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,937.5	2,947.2	1009.7
Дуусаагүй үйлдвэрлэл	66.5	79.7	13.2
Бэлэн бүтээгдэхүүн	6,564.1	35,256.3	28,692.2
Хангамжийн материал	10,407.5	11,446.7	1,039.2
Мал амьтад	373.1	463.5	90.4
Дүн	19,348.7	51,193.5	31,884.8

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалыг байгууллагын бүтцээр нь авч үзвэл 39,316.6 сая төгрөг буюу 76.8 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 11,876.9 сая төгрөг буюу 23.2 хувийг төсөвт байгууллагын бараа материал тус тус эзэлж байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Ханбогд сумын 29-р цэцэрлэг 1.3 сая төгрөгийн, Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэг 1.4 сая төгрөгийн материал дутагдуулсан,
- Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэг агуулахын бүртгэлийг хөтлөөгүй, нүүрс худалдан авсан тоо хэмжээ тодорхойгүй, бараа материал хүлээн авалтын баримт үйлдээгүй,
- Номгон сумын ЭМТ бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 61.0 сая төгрөгийн бараа материал хүлээн авч зарлага гаргахдаа эд хариуцагчийн тайлан бэлтгээгүй,
- Баян-Овоо сумын 19 дүгээр цэцэрлэг 1.5 сая төгрөгийн, Булган сумын 5 дугаар цэцэрлэг 0.1 сая төгрөгийн, Манлай сумын 15-р цэцэрлэг 0.1 сая төгрөгийн, Ханбогд сумын 29 дүгээр цэцэрлэг 0.3 сая төгрөгийн хүүхдийн хоолны нормыг, Булган сумын ЭМТ 1.7 сая төгрөгийн шатахууны норм нормативыг тус тус хэтрүүлэн зарцуулсан,
- Булган сумын ЗДТГ буцалтгүй тусламжаар олгосон 9360 боодол тэжээлийг нягтлан бодох бүрдгэлд тусгаагүй, аймгийн мал хамгаалах санд төвлөрүүлэх 6.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 547,015.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 629,475.9 сая төгрөг болж, 82,460.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	253,406.7	310,655.4	57,248.7
Авто-тээврийн хэрэгсэл	12,233.0	13,411.8	1,178.8
Машин тоног төхөөрөмж	28,263.1	36,800.3	8,537.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,869.2	8,198.4	329.2
Зам, гүүрийн байгууламж	121,972.2	136,191.3	14,219.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,401.4	1,795.2	393.8
Бусад үндсэн хөрөнгө	56,027.0	55,926.3	-100.7
Дуусаагүй барилга, байгууламж	4,482.8	4,362.8	-120.0
Ном	1,076.0	1,160.4	84.4
Программ хангамж	1,887.7	1,635.6	-252.1
Бусад биет бус хөрөнгө	58,385.3	59,338.4	953.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/	10.9	0.0	-10.9
Дүн	547,015.5	629,475.9	82,460.6

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд худалдан авсан 1,924.2 сая төгрөгийн, балансаас баланст шилжүүлсэн 11,230.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүй хандиваар авсан 6,195.0 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр болон бусад шалтгаанаар шилжүүлэн авсан 109,698.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Балансаас баланст шилжүүлсэн 3,645.4 сая төгрөгийн, акталсан 8,525.2 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр болон бусад шалтгаанаар 5,345.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд Даланзадгад суманд Соёл, спортын цогцолборын барилга 3,966.5 сая төгрөг, Хүрмэн сумын хүн эмнэлгийн барилга 270.3 сая төгрөг, Мандал-Овоо сумын ЗДТГ-ын Өтгөн багийн өндөр хүчдэлийн 48.9 сая төгрөгийг шугамын ажлуудыг улсын комиссын актаар хүлээн аваагүй зэрэг шалтгаантайгаар бүртгэлтэй байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Номгон сумын ЭМТ, Цогт-Овоо сумын ЗДТГ, ИТХ, 12-р цэцэрлэг хөрөнгийн тооллогын комисс байгуулсан боловч хийсэн гэх нотлох баримт байхгүй,
- Сэврэй сумын ЗДТГ 7.9 сая төгрөгийн эд хогшлыг, Ханбогд сумын ЗДТГ 34.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй,
- Ханбогд сумын 22 дугаар цэцэрлэгт 47 нэр төрлийн 262 ширхэг, ЗДТГ-т 191 нэр төрлийн 2115 ширхэг, ИТХ-д 26 нэр төрлийн 36 ширхэг үлдэх хөрөнгөгүй хөрөнгө бүртгэлтэй байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 145,713.8 сая, эцсийн үлдэгдэл 222,226.3 сая төгрөг болж, 76,512.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	86,372.4	131,558.1	45,185.7	59.2
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	755.4	822.1	66.7	0.4
Ажилчидтай холбогдсон өглөг	137.2	206.0	68.8	0.09
Бараа үйлчилгээний зардлын өглөг	15.7	150.9	135.2	0.07
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	20,391.1	16,534.3	-3,856.8	7.4

Зээлийн хүүгийн өглөг	744.5	769.1	24.6	
Бусад өглөг	41,151.6	64,608.3	42,472.0	29.1
Урьдчилж орсон орлого	23,176.9	48,467.4	25,290.5	21.8
Урт хугацаат өр төлбөр дүн	59,341.4	90,668.2	31,326.8	40.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	7,973.9	8,481.6	1,008.4	3.8
Хойшлогдсон татварын өр /ТӨҮГ/	51,343.7	82,186.6	30,842.9	37.3
Бусад өр төлбөр /ТӨҮГ/	23.8	0.0	-23.8	0.0
Нийт дүн	145,713.8	222,226.3	76,512.5	100

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 16,534.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дуусаагүй ажил, 14,840.1 сая төгрөгийн барьцаа, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын татвар, нийгмийн даатгал, ногдол ашиг болон бусад 98,235.7 сая төгрөгийн өглөг, Гүний ус ХХК-ийн зээл, зээлийн хүүгийн 1,591.2 сая төгрөгийн өр байна.

Богино хугацаат өр төлбөрийн 17,217.9 сая төгрөг буюу 13.1 хувийг төсөвт байгууллага, 16,308.4 сая төгрөг буюу 12.4 хувийг тусгай зориулалтын сан, 98,031.9 сая төгрөг буюу 74.5 хувийг ОНӨҮГ-ууд эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ОНӨААТҮГ-удын хойшлогдсон өр төлбөр 82,186.6 сая төгрөг /СТОУС 20-ын дагуу/, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 7,922.8 сая төгрөг, /Зүүн өмнөд говийн бүсийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл хүрээнд тус аймагт цэвэрлэх байгууламж барих ажил/, Гүний ус ХХК-ийн 558.7 сая төгрөгийн /2004 онд хэрэгжсэн Азийн хөгжлийн банкны нийтийн аж ахуйн төсөл 1,101.2 сая төгрөгийн зээл/ өр төлбөр бүртгэлтэй байна.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 657,109.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 665,718.2 сая төгрөг болж, 8,608.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9 Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	167,292.3	160,256.1	-7,036.2	24.1
Хуримтлагдсан үр дүн	462,051.4	477,000.3	14,948.9	71.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,765.9	28,461.8	695.9	4.3
Дүн	657,109.6	665,718.2	8,608.6	100.0

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 665,718.2 сая төгрөг болж 8,608.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 28,461.8 сая төгрөг болж 695.9 сая төгрөгөөр өссөн нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс шалтгаалсан,
- Хуримтлагдсан үр дүн 477,000.3 сая төгрөг болж 14,948.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5.9 Орлогын данс

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 9,338.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2,524.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,813.5 сая төгрөгөөр тасалсан байна.

3.5.10 Зардлын данс

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас зардлын данстай холбоотой төсвийг үр ашиггүй зориулалт бусаар зарцуулсан, эдийн засгийн ангиллыг зөрчсөн, төрийн сангийн төлбөр тооцоог хяналтгүй зарцуулсан дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Ханхонгор сумын ЗДТГ хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтанд 1.6 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон,
- Даланзадгад сумын ИТХ, Ханбогд сумын 2 дугаар сургууль Захиргааны хэргийн 103 дугаар зүйлийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй,
- Аймгийн ИТХ 3.9 сая төгрөгийн түлш халаалтын хөнгөлөлтийг цалингийн зардлаас олгосон, хурлын даргын нөөц сангаас нийт 69.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Ханбогд сумын ЗДТГ урсгал засварын зардлаас 6.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн,
- Цогт-Овоо сумын 12-р цэцэрлэг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 15.9 сая төгрөгийн, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл зардлаас 4.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн,
- Баяндалай сум 80.0 сая төгрөгийг, Мандал-Овоо сум 65.9 сая төгрөгийг, Ноён сум 19.2 сая төгрөгийг тус тус зөвлөлийн хурлаар хэлэлцээгүй зарцуулсан,
- Баяндалай сум 4.1 сая төгрөгийг, Мандал-Овоо сум 0.8 сая төгрөгийг, Ноён сум 1.1 сая төгрөгийг хүчингүй болсон журмын заалтаар захиран зарцуулсан,
- Аймгийн засаг даргын нөөц сангаас зориулалтын бус зардал гаргасан тухайлбал, зарим байгууллагын ажилчдыг чадавхжуулах сургалтын төлбөр, албан томилолтын зардал, ойн арга хэмжээ зохион байгуулах зардалд 33.2 сая төгрөг, 9.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ОНӨААТҮГ-ын урсгал засвар, сэлбэг хэрэгсэлд, иргэдийн орон сууцны нөхцөл байдлаа сайжруулах, засварлах зэрэгт нийт 43.0 сая төгрөг зарцуулсан,
- Тайланд онд 224.2 сая төгрөгийн 70 гүйлгээг төлбөрийн хүсэлт бичигдсэн өдрөөс хойш ажлын 3 хоног хэтэрсэн байхад гүйлгээ хийсэн,
- Төрийн үйлчилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хилийн цэргийн 0131-р анги, Санхүүгийн хяналт аудитын албаны орлого хаах гүйлгээ, Халамжийн сан, сумдад олгох татаас, улсын тэмдэгтийн хураамжийн гүйлгээнүүд батлагдсан маягтаас зөрүүтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахдаа энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Өмнөговь аймгийн ИТХ-ын 3/2 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд зааснаар тайлант онд 257,079.1 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 228,923.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөг 89.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5
НИЙТ ОРЛОГО	178,355.8	257,079.1	228,923.4	(28,155.7)	89.0
УРСГАЛ ОРЛОГО	128,935.6	203,274.5	176,487.9	(26,786.6)	86.8
Татварын орлого	111,726.8	138,846.2	137,595.7	(1,250.5)	99.1
Орлогын албан татвар	48,681.7	63,810.4	68,370.5	4,560.1	107.1

Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	45,184.2	61,990.9	65,310.6	3,319.7	105.4
Үйл ажиллагааны орлого	2,417.7	714.5	1,867.1	1,152.6	261.3
Бусад орлого		1,787.1	1,748.3	(38.8)	97.8
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний ОАТ	1,924.6	317.9	392.3	74.4	123.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(844.8)	(1,000.0)	(947.7)	52.3	94.8
Өмчийн татвар	27,866.8	28,296.4	30,585.7	2,289.3	108.1
Үл хөдлөх хөрөнгийн татвар	27,830.6	28,260.0	30,545.2	2,285.2	108.1
Бууны албан татвар	36.3	36.4	40.5	4.1	111.3
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	6,670.8	7,000.0	8,683.2	1,683.2	124.0
АТ болон ӨЯ хэрэгслийн албан татвар	6,670.8	7,000.0	8,683.2	1,683.2	124.0
Бусад татвар /төлбөр хураамж/	28,507.5	39,739.4	29,956.3	(9,783.1)	75.4
Улсын тэмдэгтийн хураамж	418.1	670.3	439.6	(230.7)	65.6
Газрын төлбөр	7,743.6	15,017.6	7,877.0	(7,140.6)	52.5
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	2,082.3	2,350.0	3,827.1	1,477.1	162.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		-	11.4	11.4	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		149.5	360.2	210.7	241.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	16,315.0	19,030.4	13,934.6	(5,095.8)	73.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,239.5	1,916.5	2,572.3	655.7	134.2
Бусад татвар хураамж	236.0	202.7	288.2	85.5	142.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	473.1	402.4	646.1	243.7	160.6
Татварын бус орлого	16,777.2	63,985.8	38,412.4	(25,573.4)	60.0
Хувьцааны ногдол ашиг	10,502.4	26,500.0	25,691.8	(808.2)	97.0
Түрээсийн орлого	39.3	24.0	88.0	64.0	366.7
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,060.2	9,338.01	2,524.5	(6,813.5)	27.0
Урьд оны шилжих үлдэгдэл		22,370.44	4,986.1	(17,384.3)	22.3
Хүү, торгуулийн орлого	3,184.6	4,507.9	4,305.3	(202.6)	95.5
Бусад орлого	982.3	1,245.4	816.6	(428.8)	65.6
Газрын тосны орлого	8.4	-	-	-	
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	431.7	442.6	479.9	37.3	108.4
Хөрөнгө борлуулсны орлого	431.7	442.6	479.9	37.3	108.4
ШИЛЖИХ ҮЛДЭГДЭЛ		-	-	-	
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	49,420.2	53,804.5	52,435.5	(1,369.1)	97.5
ОНХН сангаас шилжүүлсэн орлого	13,941.3	17,014.6	17,014.6	0.0	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	35,277.3	36,350.6	35,221.9	(1,128.7)	96.9
Бусад тусламж	201.6	439.3	198.9	(240.4)	45.3

Орон нутгийн төсвийн орлого 28,155.7 сая төгрөгөөр тасарсан шалтгааныг Өмнөговь аймгийн Татварын хэлтсээс тодруулахад орлогын төлөвлөгөө нэр төрлөөр тасалсан шалтгааныг 2022 оны 04-р сарын 13-ны өдрийн 1/278 албан бичгээр дараах байдлаар ирүүлсэн байна.

-Газрын төлбөр нь 2021 оны төлөвлөснөөс 7,140.6 сая төгрөгөөр тасарсан нь Сангийн яамнаас аймгийн суурь орлогыг тооцоолохдоо Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн 2021 оны газрын төлбөрийн ногдуулалтаас хэт өндөр төлөвлөсөн,

- Үйлдвэрлэл үйлчилгээний ус ашигласны төлбөрийг төлөвлөхдөө ус ашиглах дүгнэлтийг үндэслэж төлөвлөдөг боловч Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10.1.3 “уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр” гэж заасны дагуу уул уурхайн компаниуд төлөлтөө хийдэг. Жишээ нь Оюутолгой ХХК-ий усны ашиглах

дүгнэлт өндөр байдаг боловч төлбөрөө төлөхдөө тоолуурын заалтаар ашигласан усны төлбөрийг төлдөг. Тус компани нийт усны хэрэглээний 85 хувь нь саарал ус буюу ашигласан усаа цөөрөмд хадгалж байгаад дахин ашигладаг, 15 хувийг нь газрын гүнээс ашиглаж, ус ашигласны төлбөрийн тооцоогоо хийдэг,

Татварын бус орлогын хувьд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан нь голлон нөлөөлсөн ба 2013, 2014 онд “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн авлага төлөгдөөгүйтэй холбоотой.

Тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор 36,350.6 сая төгрөг төлөвлөж, 35,221.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, улсын төсөвт 1,128.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих орлого 439.3 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 198.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Сангийн яамнаас аймгийн нийт орлого, зарлагын дүнг 154,694.0 сая төгрөгөөр хянасан бөгөөд Өмнөговь аймгийн ИТХ-ын 2021 оны 3/2 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2021 оны төсвийн тухай” тогтоолд зааснаар тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 257,079.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 257,079.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Оны эцэст Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өмнөговь аймгийн ИТХ 2021 оны 3/2 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 8,177.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 23 хөтөлбөрт зориулан 257,079.0 сая төгрөг, үүнээс 164,494.7 сая төгрөгийг урсгал зардалд, 92,584.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 53,365.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 183,543.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 439.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 19,731.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого (өөрийн орлого 9,338.0 сая төгрөг болон шилжих үлдэгдэл 10,393.2 сая төгрөг) -оос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 52,236.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 173,963.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 198.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2,524.5 сая төгрөг нийт 228,923.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаа буюу үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 2,524.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсанаас 6,813.5 сая төгрөгөөр тасарсны дийлэнх нь “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн авлага барагдаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт №10. Төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү +/-	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Б	1	2	3	4=3-2	5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,686.4	257,079.1	230,081.8	26,997.3	89.5
УРСГАЛ ЗАРДАЛ	111,516.3	164,494.7	155,306.9	9,187.8	94.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,681.6	84,386.1	75,444.3	8,941.8	89.4

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,898.7	39,213.1	37,914.4	1,298.7	96.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,735.8	5,429.4	5,086.8	342.6	93.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,669.3	7,590.5	6,331.4	1,259.1	83.4
Хангамж, бараа материалын зардал	2,345.4	2,795.1	2,603.4	191.7	93.1
Нормативт зардал	1,997.0	1,940.3	1,554.8	385.5	80.1
Эд хогшил, урсгал засварын зардал	454.9	1,338.5	1,233.8	104.7	92.2
Томилолт, зочны зардал	95.0	183.7	141.9	41.8	77.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,566.4	4,999.3	4,038.4	960.9	80.8
Бараа үйлчилгээний бусад зардал	18,919.1	20,896.0	16,539.2	4,356.8	79.2
ТАТААС	145.9	45.5	45.5	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	145.9	45.5	45.5	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,688.8	80,063.1	79,817.1	246.0	99.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	36,353.5	78,702.5	78,701.9	0.6	100.0
Бусад урсгал шилжүүлэг	1,335.3	1,360.6	1,115.3	245.4	82.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,170.1	92,584.4	74,774.9	17,809.5	80.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		-	-	-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	204,376.2	257,079.1	228,923.4	28,155.7	89.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,799.5	53,365.2	52,236.6	1,128.6	97.9
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	32,858.2	36,350.6	35,221.9	1,128.7	96.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	13,941.3	17,014.6	17,014.6	(0.0)	100.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	155,314.9	183,543.2	173,963.4	9,579.8	94.8
Орон нутгийн төсвөөс	155,314.9	183,543.2	173,963.4	9,579.8	94.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,060.2	9,338.0	2,524.5	6,813.5	27.0
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИХ	201.6	439.3	198.9	240.4	45.3
БУСАД ЭХ ҮҮСВЭР / шилжих үлдэгдэл/		10,393.3		10,393.3	0.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,964.1		8,653.8		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,653.8		7,495.4		

ыТөсвийн нийт зардлын гүйцэтгэл 230,081.7 сая төгрөг буюу 89.5 хувьтай байгаагийн дотор урсгал зардлын гүйцэтгэл 85.1 хувьтай, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 80.8 хувьтай байна. Хөрөнгө оруулалтын 114 төсөл, арга хэмжээнд 70,002.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 58,347.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, хөрөнгийн зардал 11,655.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь хөрөнгө оруулалтын ажлууд тайлант ондоо багтаж хийгдээгүйтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 1,128.6 сая төгрөг, газрын албаны төвлөрүүлэх шилжүүлэг 254.2 сая төгрөгийг улсын төсөвт, орон нутгийн төсвийн байгууллагуудын 4,411.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 “*нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна*” –д заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 85.9 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 10,367.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 2,958.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,929.4 сая төгрөг нийт 16,340.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт №11. Нэмэлт төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Салбарын болон байгууллагын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он		
			Санхүүжилт	Зарцуулалт	Үлдэгдэл
А	Б	1	2	3	4
1	Баяндалай	1,360.80	981.3	981.3	-
2	Баян-Овоо	1,213.50	191.3	191.3	-
3	Булган	1,037.00	368.5	367.0	1.5
4	Гурвантэс	1,755.20	1,817.1	1,817.1	-
5	Мандал-Овоо	1,937.80	2,034.4	2,034.4	-
6	Манлай	1,798.80	642.5	637.2	5.3
7	Номгон	925.80	243.4	238.1	5.3
8	Ноён	492.70	272.9	272.9	-
9	Сэврэй	1,385.60	2,045.8	2,045.7	0.1
10	Ханбогд	1,616.90	1,211.2	1,205.5	5.7
11	Ханхонгор	427.90	527.4	526.8	0.6
12	Хүрмэн	221.10	165.2	165.2	-
13	Цогт-Овоо	1,304.20	1,326.7	1,319.9	6.8
14	Цогтцэций	1,032.80	795.2	792.4	2.8
15	Даланзадгад	8,615.60	1,005.3	1,005.3	-
16	Аймгийн төвийн төсвийн байгууллагууд	3,463.80	2,712.3	2,712.3	-
ДҮН		28,589.5	16,340.5	16,312.4	28.1

Нэмэлт санхүүжилтийн 62.6 хувь буюу 10,188.4 сая төгрөг бараа үйлчилгээний зардал буюу ОНТХО, ОНХС-ийн эрх шилжсэн төсөл арга хэмжээний санхүүжилт байна.

Мөн төрийн албан хаагчдад олгосон нутгийн дэм, мал хамгаалах сангийн мал эмнэлгийн үйлчилгээ, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилт сумдад хуваарилагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг нээхдээ эдийн засгийн ангиллыг баримтлахгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.7.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг “Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалтын санхүүжилтийг өссөн дүнгээр мэдээлээгүйд албан шаардлага хүргүүлжээ.

3.7.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг шалгахад Засаг даргын нөөц сангаас албан томилолтын зардал, ой арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулах зардалд 19.7 сая төгрөг зарцуулсанд албан шаардлага хүргүүлээ.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Аймгийн ИТХ 32.61 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн,
- Аймгийн ИТХ 32.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Манлай сумын ИТХ 20.0 сая төгрөгийн автомашин худалдан авсан,
- Аймгийн ИТХ 8.7 сая төгрөгийн, Сэврэй сумын ЗДТГ 10.8 сая төгрөгийн, цэцэрлэг 1.4 сая төгрөгийн, Манлай сумын ЗДТГ 9.0 сая төгрөгийн ажлын хувцас тус тус бэлтгэсэн,
- Аймгийн ИТХ 27.6 сая төгрөгийг, Сэврэй сумын ЗДТГ 2.6 сая төгрөгийг, ИТХ 2.4 сая төгрөгийг, Манлай сумын ИТХ 5.6 сая төгрөгийг тус тус уралдаан тэмцээн, ойн арга хэмжээнд зарцуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтуудтай нийцээгүй, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалгасан Засгийн газрын 2021 оны төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний 43 дугаар тогтоолын 1.5, 1.6-д заасантай тус тус нийцээгүй байна.

3.8 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 53 байгууллагад завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн. Завсрын аудитаар дараах зөрчлүүд илэрсэн.

- Сэврэй сумын ЗДТГ-ын хөрөнгийн тооллогын комисс байгуулагдсан боловч хөрөнгийн тооллого хийгээгүй,
- Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэг, Баяндалай сумын ЗДТГ эхний хагас жилийн тооллого болон нярав солигдоход эд хөрөнгийн тооллого хийгээгүй,
- Номгон сумын ЭМТ хөрөнгийн тооллогын комисс байгуулан тооллого хийсэн боловч тооллогын бүртгэлд комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй, комисс ажилласан тухай нотлох баримтгүй,
- Баяндалай сумын ЗДТГ хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй үндсэн хөрөнгөд холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй,
- Манлай, Номгон, Ноён, Сэврэй, Ханбогд сумдын ЗДТГ хандив болон орон нутгаас олгосон өвс тэжээлийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй,
- Баяндалай сумын ЗДТГ 63.9 сая төгрөгийн өвс тэжээлийн авлагыг бүртгэлд тусгаагүй,
- Манлай сумын ЗДТГ 24.6 сая төгрөгийн өвс тэжээл дутагдуулсан
- Аймгийн ЗДТГ хэвлэл мэдээллийн зардлаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан санхүүжилт олгосон,
- Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэг эхний хагас жил, 3-р улирлын тайлан баланс гаргаж баталгаажуулаагүй,
- Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэг, Цогт-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогчийг аймгийн төрийн сангийн хэлтсийн даргатай зөвшилцөн томилоогүй,
- Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэг байгууллагын эмчийн албан тушаалд сэтгүүлч мэргэжилтэй хүн авч цалинжуулсан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 10,349.1 сая төгрөгийн 7 зөвлөмж, зөрчлийг таслан зогсоох 1,879.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт:

Хүснэгт №12 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	7	10,349.1	7	10,349.1			100.0
Албан шаардлага	1	1,879.0	1	1,851.1		27.9	98.6
Төлбөрийн акт	0	0	0	0			0
Нийт	8	12,228.1	8	12,200.2		27.9	99.3

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 132 төсвийн байгууллага, 38 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж, 36 тусгай сан, 15 төсвийн төвлөрүүлэн захирагч, нийт 223 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 144 байгууллагад дүгнэлт гаргаж, 79 байгууллага түүвэрт хамрагдсан.

Байгууллагын нэр	Байгууллага нэгжийн тоо			Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнэс: аудит хийсэн хэлбэр		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Санал дүгнэлт гаргах	Түүвэрт				
ТШЗ	132	111	21	83	27	1	0
ОНТС	36		36				
ОНӨААН	38	16	22	12	4		
ОНӨОААН	2	2		2			
ТТЗ	15	15		15			
Нийт дүн	223	144	79	112	31	1	0

Аудитад хамрагдсан 112 байгууллагад “Зөрчилгүй”, 31 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

Хязгаарлалттай болон сөрөг дүгнэлт авсан байгууллагууд:

№	Байгууллагын нэр	Ангилал	Дүгнэлтийн хэлбэр
1	Баяндалай сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалттай
2	Баяндалай сумын ерөнхий боловсролын сургууль	ТШЗ	Хязгаарлалттай
3	Баяндалай сумын 13 дугаар цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
4	Булган сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТШЗ	Хязгаарлалттай
5	Булган сумын засаг даргын Тамгын газар	ТШЗ	Хязгаарлалттай
6	Булган сумын 5 дугаар цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
7	Гурвантэс сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТШЗ	Хязгаарлалттай
8	Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
9	Даланзадгад сумын 9 дүгээр цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
10	Даланзадгад сумын 23 дугаар цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
11	“Говийн ирээдүй” ОНӨААТҮГ	ОНӨААН	Хязгаарлалттай
12	Мандал-Овоо сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТШЗ	Хязгаарлалттай
13	Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв	ТШЗ	Хязгаарлалттай

14	Мандал-Овоо сумын 17 дугаар цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалтай
15	Манлай сумын засаг даргын Тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
16	Манлай сумын Эрүүл мэндийн төв	ТШЗ	Хязгаарлалтай
17	Номгон сумын засаг даргын Тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
18	Номгон сумын 14 дүгээр цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалтай
19	Сэврэй сумын засаг даргын Тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
20	Сэврэй сумын “Нийтлэг үйлчилгээний газар” ОНӨААТҮГ	ОНӨААН	Хязгаарлалтай
21	Ханбогд сумын 2 дугаар сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
22	Ханбогд сумын эрүүл мэндийн төв	ТТЗ	Хязгаарлалтай
23	“Хот тохижилт” ОНӨААТҮГ	ОНӨААН	Хязгаарлалтай
24	Ханхонгор сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТТЗ	Хязгаарлалтай
25	Ханхонгор сумын эрүүл мэндийн төв	ТТЗ	Хязгаарлалтай
26	Цогт-Овоо сумын 12 дугаар цэцэрлэг	ТТЗ	Хязгаарлалтай
27	Цогтцэций сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТТЗ	Хязгаарлалтай
28	Цогтцэций сумын эрүүл мэндийн төв	ТТЗ	Хязгаарлалтай
29	Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэг	ТТЗ	Хязгаарлалтай
30	Ахмадын чөлөөт холбоо	ТШЗ	Хязгаарлалтай
31	“Хөгжил хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ	ОНӨААН	Хязгаарлалтай
32	Номгон сумын эрүүл мэндийн төв	ТШЗ	Сөрөг

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 94,113.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 55,126.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 38.7 сая төгрөгийн зөрчилд 25 төлбөрийн акт тогтоож, 22,661.6 сая төгрөгийн зөрчилд 174 албан шаардлага, 16,286.5 сая төгрөгийн зөрчилд 260 зөвлөмж өгч, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 11 албан тушаалтад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэхдээ сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулах зөрчлүүд илэрч байгааг хөрөнгө оруулалт болон ОНХС-нд гүйцэтгэх гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.11 Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,001.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 10.0 сая төгрөгийн алдааг залруулж, 766.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 224.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 991.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 1,941.3 сая төгрөгийн материаллаг алдааны түвшнээс 950.2 сая төгрөгөөр бага байгаа тул “зөрчилгүй” дүгнэлт өглөө.

1. Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 10.0 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Засаг даргын нөөц сангаас иргэнд олгосон 10.0 сая төгрөгийн гүйлгээнд орлогын ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг илгээгээгүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 “Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ”-д заасныг хэрэгжүүлээгүй нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2. Албан шаардлага

Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 9,039.250 төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, урсгал засвар, сэлбэг хэрэгсэлд, иргэдийн орон сууцны нөхцөл байдлаа сайжруулах, засварлах зэрэгт

43,000.000 төгрөг зарцуулсан, мөн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, болон төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 3/2 дугаар тогтоолын зургаадугаар хавсралтаар 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүд батлагдан хэрэгжиж байхад зориулалтаас өөр эх үүсвэрээс байгууллагын ажилчдыг чадавхжуулах сургалтын төлбөрт 13,500.000 төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2 "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 6.5 "нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нээж, төсвийн захирагч тус хяналт тавина", 7.1 "төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" -д заасантай нийцэхгүй байна.

- Таван сантай холбоотой 364.3 сая төгрөг, зээлийн эзэн холбогдогч нь тодорхойгүй 50.3 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 267.0 сая төгрөгийн 6-9 жилийн насжилттай авлага бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд, хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

- Баян-Овоо, Баяндалай, Цогт-Овоо сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагч өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

3.1 Дотоод аудитын холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит нь 2021 онд 186 байгууллагын 3 байгууллагад дотоод аудитыг, 148 байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна", Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт"-ын 3.1.3 "хяналт шалгалт явуулах хугацааг тогтоосон байна. Энэ хугацааг тогтоохдоо шалгалтын тайлан гаргах хугацааг тооцно, бага хэмжээний 1,000.0 саяас бага төгрөгийн санхүүжилт авдаг орлого зарлагатай аж ахуй нэгж байгууллага, төсөвт газарт бол 14 хоног"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагад эрсдэлээс урьдчилан сэргийлж тайлант онд дотоод аудитыг хийж арга зүйгээр хангаж ажиллах, тухайлбал өр, авлагыг үнэлэн, барагдуулах ажлыг зохион байгуулах

3.2 Төрийн сангийн төлбөр тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Төрийн үйлчилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хилийн цэргийн 0131-р анги, Санхүүгийн хяналт аудитын албаны орлого хаах гүйлгээ, Халамжийн сан, сумдад олгох татаас, улсын тэмдэгтийн хураамжийн гүйлгээнүүд батлагдсан маягтаас зөрүүтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох байгууллагуудын программын шинэчлэлийг хийлгэж төрийн сангийн төлбөр тооцооны журамд нийцүүлэх.

Илрүүлэлт 2: Тайлант онд 224.1 сая төгрөгийн 70 гүйлгээг төлбөрийн хүсэлт бичигдсэн өдрөөс хойш ажлын 3 хоног хэтэрсэн байхад гүйлгээ хийсэн байгаа нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн мэргэжилтэн журмын дагуу гүйлгээг хийж хянан баталгаажуулж байх.

3.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалтын санхүүжилтийг өссөн дүнгээр мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 8 дугаар зүйлийн 8.2 "энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" -д заасныг тус тус хэрэгжүүлээгүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж: www.shilendans.gov.mn цахим хуудсанд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн санхүүжилтийг зааврын дагуу өссөн дүнгээр мэдээлсэн байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Өмнөговь аймгийн Засаг дарга	ӨМА-2022/1/Н А-СТА-ТЭЗ	Засаг даргын нөөц сангаас иргэнд олгосон 10.0 сая төгрөгийн гүйлгээнд орлогын ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг илгээгээгүй,	Аудитын явцад залруулах	1	10.0	1	10.0								-	
2			Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 9.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, урсгал засвар, сэлбэг хэрэгсэлд, иргэдийн орон сууцны нөхцөл сайжруулах, засварлах зэрэгт 43.0 төгрөг зарцуулсан, зарим байгууллагын ажилчдыг чадавхжуулах сургалтын төлбөр,	Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2, 6.5, 7.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэн зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах	1	65.5					1	65.5					-
3			5 сантай холбоотой 364.4 сая төгрөг, зээлийн эзэн холбогдогч нь тодорхойгүй олон жилийн насжилттай 50.3 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 267.0 сая төгрөгийн авлага бүртгэлтэй,	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалтуудыг хэрэгжүүлэн зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах	1	681.7					1	681.7					
4			Баян-Овоо, Баяндалай, Цогт-Овоо сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагч өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагыг	Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 -д заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох	1										1		

			хэрэгжүүлээгүй зөрчлийн давтан гаргасан,															
5			Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит нь 2021 онд 3 байгууллагад дотоод аудитыг, 148 байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн,	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагад эрсдэлээс урьдчилан сэргийлж тайлант онд дотоод аудитыг хийж арга зүйгээр хангаж ажиллах	1												1	
6			Төсвийн 6 байгууллага батлагдсан маягтаас зөрүүтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдсэн,	Холбогдох байгууллагуудын программын шинэчлэлийг хийлгэж төрийн сангийн төлбөр тооцооны журамд нийцүүлэх	1												1	
7			Тайлант онд хийгдсэн 224.2 сая төгрөгийн 70 гүйлгээг төлбөрийн хүсэлт бичигдсэн өдрөөс хойш ажлын 3 хоног хэтэрсэн байхад гүйлгээ хийсэн,	Төрийн сангийн мэргэжилтэн журмын дагуу гүйлгээг хийж хянан баталгаажуулж байх.	1	224.2											1	224.2
ДҮН					7	981.4	1	10.0				2	747.2	1	0	3	224.2	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	Өмнөговь аймгийн Засаг дарга	ӨМА-2022/1/Н А-СТА-ТЕЗ	Засаг даргын нөөц сангаас албан томилолтын зардал, ой арга хэмжээ зохион байгуулах зардалд 33.2 сая төгрөг зарцуулсан,	Засгийн газраас баталсан төсвийн хэмнэлтийн талаар авч байгаа арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	1	19.7						1	19.7					
2			Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалтын санхүүжилтийг өссөн дүнгээр мэдээлээгүй.	www.shilendans.gov.mn цахим хуудсанд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн санхүүжилтийг зааврын дагуу өссөн дүнгээр мэдээлсэн байх.	1	-												1
ДҮН					2	19.7						1	19.7				1	-
НИЙТ ДҮН					9	1,001.1	1	10.0				3	766.9	1	0	4	224.2	